



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/02

Арвайхээр

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 в, Эрүүл мэндийн сайдын 2014 оны “Томуу, томуу төст өвчний харуулдан тандалтын тогтолцоог өргөжүүлэх тухай” 358 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд амбулаторийн үзлэгээс томуу, томуу төст өвчний эзлэх хувь 18.6 хувьд хүрч, 0-5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд өвчлөл, хүндрэл ихтэй байгаа тул 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийг дуустал аймгийн нийт цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хааж, сурагчдын улирлын амралтын хугацаанд олон нийтийг хамарсан үзвэр үйлчилгээ, соёл урлагийн арга хэмжээ, дугуйлан секц, давтлагыг хязгаарлахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Томуу, томуу төст өвчний тархалтын байдалтай холбогдуулан сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулах, томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргаж, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн, үр дүнтэй ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Э.Хүдэрчулуун), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ГАНБОЛД

011100003